

9

МУИС-ИЙН ХЭЛНИЙ МЭРГЭЖЛИЙН БУС САЛБАРУУДЫН АНГЛИ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД

Ц.Баярмаа.

Abstract

МУИС-ийн хэлний мэргэжлийн бус ангиудад англи хэлний хичээлийг сургалтын төлөвлөгөөний нийтлэг шаардлагын дагуу нэг оюутан нийт дөрвөн улирал буюу хоёр хичээлийн жилд 256 цаг (8 багц цаг) судлах ёстой. Үүнээс ерөнхий англи хэлийг долоо хоногт 4 цагаар нийт 2 улирал, мэргэжлийн англи хэлийг мөн долоо хоногт 4 цагаар 2 улирал дараалан үздэг бөгөөд ЭЗС дээр энэ хөтөлбөрийг мөрдөж байна.

2010-2011 хичээлийн жилийн хоёрдугаар улиралд ЭЗС-ийн 1,2-р ангийн нийт 352 оюутнуудын дунд санал асуулга (needs analysis) явуулж одоо мөрдөж байгаа англи хэлний сургалтын хөтөлбөрийг шинэчилж боловсронгуй болгох шаардлага байгаа эсэхийг голлон тодруулахыг зорилоо. Судалгаанд оролцсон оюутнуудын 71,5% нь сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох нь зүйтэй гэсэн санал өгчээ.

Ингээд уг судалгаанд үндэслэн суралцагчдын зорилго, хэлний хандлага, тэдний сургалтаас хүлээж байгаа хүлээлт зэрэг хэрэгцээ шаардлагад тулгуурлан англи хэлний хичээлийн хөтөлбөрийг хэрхэн сайжруулах шаардлагатай байгаа талаар хөндөхийг хичээлээ.

Англи хэлийг хоёрдогч хэл болгон судалдаг орнуудад хичээлийн хөтөлбөрийг аль болох боловсронгуй болгох ажлуудыг тогтмол хийдэг байна. Англи, Америк зэрэг орнуудын их дээд сургууль, коллежуудад англи хэлийг хоёрдогч хэл болгон судалж байгаа оюутнуудад зориулсан сургалтын хөтөлбөрүүд байх боловч энэ нь ихэвчлэн олон үндэстний суралцагчидтай ангид зориулагдсан байдаг нь манай нэг хэлний суралцагчидтай ангиудад тэр болгон тохирохгүй байдаг. Харин Хятад зэрэг азийн орнуудад дээд боловсролын сургалтанд зориулагдсан англи хэлийг эрчимтэй сурах сургалтын

хөтөлбөрүүдийг боловсруулан нийгмийн хэрэгцээ шаардлагад тохируулан сайжруулж ирсэн байна. Ялангуяа Хятад улсад дээд боловсролын түвшний англи хэлний үндэсний хөтөлбөрийг боловсруулан мөрддөг, түүнийгээ суралцагчид болон нийгмийн шаардлагад нийцүүлэн өөрчлөн сайжруулж байдаг тул хятад оюутнуудын англи хэлний мэдлэгийн түвшин сүүлийн жилүүдэд эрс дээшилж байгаа талаар хийсэн судалгаа олон байна.

Иймд МУИС-ийн хэлний мэргэжлийн бус ангиудын англи хэлний сургалтын хөтөлбөрийг сайжруулж нэгдсэн стандарт гаргахаар ГХСТ-ийн багш нарын баг ажиллаж байгаа бөгөөд энд хятадын үндэсний хөтөлбөрөөс санаа авч тусгах зүйлсийг хөндлөө.

Судалгааны үр дүнд шинжилгээ хийсэн байдал

БСШУЯ-ны дэвшүүлсэн “Дээд Боловсролын Хөгжлийн Бодлогын Зорилт- 2021”- д “Дээд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, судалгааны чиглэлийг нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох..., олон улсын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй болгох..., дээд боловсрол эзэмшигчид ажил, мэргэжлээрээ шаардлагатай мэдээллийг англи хэлээр ашиглах чадвартай болгох..” зэрэг стратеги зорилтуудыг дэвшүүлжээ.

Монгол Улсын их дээд сургуулиудад англи хэлийг хэлний мэргэжлийн ангийн оюутнуудад болон хэлний бус мэргэжлийн ангийн оюутнуудад зориулсан хоёр үндсэн хөтөлбөрөөр зааж байна.

Хэлний мэргэжлийн бус ангийн оюутнууд нь менежмент, эдийн засаг, инженер, байгалын ухаан, хууль, анагаах ухаан гэх мэт олон төрлийн салбаруудад мэргэжин сурч байгаа оюутнууд бөгөөд ихэнх их дээд сургуулиудын хэлний мэргэжлийн бус англи хэлний хичээлийн тодорхойлолтуудад мэргэжлийн ном сурах бичиг, сонин сэтгүүл болон мэдээ мэдээллийг англиар уншиж ашиглах, англи хэлээр харилцан ойлголцох, энгийн болон албан захиа бичих зэрэг мэдлэг чадварыг түвшин түвшинд нь эзэмшүүлнэ гэж заасан байдаг.

Гэвч МУИС-д суралцагчдийн англи хэлний түвшин, тус хичээлийн сургалтын байдалд үнэлгээ хийх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах зорилгоор БСА-ны дэргэд ажилладаг англи хэлний заах арга зүйн зөвлөлөөс явуулсан “Нөхцөл байдлын үнэлгээ, шинжилгээ” –ний дүнгээс харвал ажил олгогч нарын үзсэнээр англи хэлний ярианы, бичгийн ур чадвартай төгсөгчид маш их эрэлт хэрэгцээтэй байгаа ч харамсалтай нь их дээд сургуулиудын төгсөгчдийн англи хэлний мэдлэг шаардлага хангадаггүй гээд шалтгаан нь их сургуулиудын хөтөлбөрт гадаад хэлний хичээл хангалттай ордоггүй, хэлний мэдлэгээ дадлагажуулах орчин хомс байдаг гэжээ (2009-2010 оны МУИС-ын Баклаврын албаны тайлан).

Үүнээс үзэхэд МУИС-ийн хэлний мэргэжлийн бус англи хэлний сургалтын хөтөлбөрт шинэчлэлт хийх шаардлага хэдийн үүсээд байгаа нь

харагдаж байгаа бөгөөд ЭЗС-ийн оюутнуудын дунд явуулсан санал асуулгын дүнг авч үзвэл англи хэлний сургалтын чанарт нөлөөлж байгаа зарим шалтгаануудад:

1. Ерөнхий Боловсролын Сүргүүлийн англи хэлний сургалтын чанар хангалтгүй байгаа байдал

ЭЗС-ийн хувьд авч үзвэл 2009-2010, 2010-2011 оны хичээлийн жилд суралцаж байгаа 1 –р курсийн оюутнууд англи хэлний түвшний хувьд нийт 16 бүлэгт хуваагдан хичээллэж байгаа бөгөөд 2-р курсийн оюутнууд 14 бүлэгт хичээллэж байна. 2-р курсийн оюутнуудад бизнесийн англи хэлний хичээлийг ‘Market Leader’ (David Cotton et al., 2006) номны шинэчилсэн сурах бичгээр Upper-Intermediate түвшний 4 бүлэг, Intermediate түвшний 4 бүлэг, Pre-Intermediate түвшний 6 бүлэгт тус тус зааж байна. 1-р курсийн оюутнуудын хувьд ‘Face2Face’ (Chris Redston et al.) сурах бичгээр Upper-Intermediate түвшний 4 бүлэг, Intermediate түвшний 2 бүлэг, Pre-Intermediate түвшний 10 бүлэгт хуваагдан хичээллэж байна.

Ингэж түвшингээр хуваасан байдлыг ажиглахад хэдийгээр ерөнхий боловсролын сургуулиудад үндэсний хэмжээнд батлагдсан гадаад хэлний боловсролын стандарт мөрдөж англи хэлийг бага боловсролын түвшингээс эхлээд бүрэн дунд боловсролын түвшин хүртэл системтэйгээр үзэн дундаас дээш түвшинд төгсгөх хөтөлбөртэй ч ЭЗС-д элсэн орж байгаа оюутнуудын 30 орчим хувь нь анхан шатны түвшинтэй орж ирж байна. 2010-2011 оны хичээлийн жилд ЭЗС-ийн 1-р курсын англи хэлний түвшингээр хуваасан сүүлийн 4 бүлэг буюу 13,14,15,16-р бүлгийн оюутнуудад 24 цагийн анхан шатны дүрмийн түргэвчилсэн програмтай хичээл урьдчилсан орж Pre-Intermediate түвшинд хүргэж хичээлийг цаашид үндсэн хөтөлбөрөөр явуулахаас аргагүйд хүрсэн.

352 оюутнаас авсан санал асуулгын “Таны англи хэлний түвшин Elementary/Pre-Intermediate байгаа бол ерөнхий боловсролын сургуульд хэлний түвшингээ дээшлүүлж чадаагүй шалтгаанаа дурьдана уу” гэсэн асуултанд өөр хэл үзэж байсан 9,5%, олон багш солигдсон-26,2%, хэлэнд сонирхолгүй байсан-14,3%, заах арга муу-24,4%, сурах бичиг тохиромжгүй-2,9%, анги дүүргэлт их 4,1%, хувь хүний хичээл зүтгэл муу-16,1%, болон бусад-2,4% гэсэн хариулт тус тус өгчээ. Үүнээс дүгнэхэд ерөнхий боловсролын сургуульд англи хэлний багшийн тогтвор суурьшил, заах арга сайн биш байгаа нь их дээд сургуулиудад элсэн орж байгаа оюутнуудын англи хэлний түвшин доогуур байх шалтгаан болж байна. Мөн хувь хүний хичээл зүтгэл муу, хэлэнд сонирхолгүй байх, өөр хэл үзэх гэх мэт шалтгаанаар тэдний англи хэлний түвшин дээшлээгүй байгаа нь харагдаж байна. Иймд ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлэх, сургалтын хөтөлбөрийг их дээд сургуулиудын хөтөлбөртэй уялдуулах шаардлагатай байна.

2. МУИС-ийн бүх салбар сургуулиудад англи хэлний түвшингээр ялгаж хичээллүүлэх

ЭЗС- д ТАСИС хөтөлбөр хэрэгжиж байсан 1996-1997 оны хичээлийн жилээс эхлэн тус сургуулийн оюутнуудыг англи хэлний мэдлэгийн түвшингээр нь бүлэг болгон хувааж хичээллүүлэх боломжтой болсон нь англи хэлний хичээлийн хөтөлбөрт хийсэн нэг эерэг шинэчлэлт байсан бөгөөд ингэж мэдлэгийн түвшингээр ялгаатай бүлгүүдэд хичээллүүлэх ажлыг ЭЗС-ийн англи хэлний тэнхмээс МУИС-ийн бусад бүрэлдэхүүн сургуулиуд дээр хэрэгжүүлсэн нь хичээлийн чанарт ахиц гарахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн. Гэвч харамсалтай нь одоогийн байдлаар зарим сургуулиуд (НУФ гм) дээр анги танхим, багш дутагдалтай гэсэн шалтгаанаар англи хэлний хичээлийг түвшингээр нь зааж чадахгүй байгаа байдал ажиглагдаж байна.

3. Их дээд сургуулиудийн хэлний мэргэжлийн бүс ангиудад үздэг англи хэлний хичээлийн нийт цаг хангалтгүй байгаа байдал

Асуулгын “Таны эзэмшиж буй мэргэжилд англи хэлний хэрэгцээ хэр их гэж үзэж байна” гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт 352 оюутны 74% маш их, 23,8% нь ер нь хэрэгтэй, 1,7% нь нэг их шаардлагагүй гэжээ. Англи хэлний хичээл 7 хоногт 4 цагаар орж байгааг хангалттай гэж үзэж байна уу гэсэн асуултанд хариулсан Pre-Intermediate түвшний 159 оюутны 71,6% нь хангалттай, 28,4% нь хангалтгүй, Intermediate болон Upper-Intermediate түвшний нийт 193 оюутны 64,2% нь хангалттай, 35,8% нь хангалтгүй гэж хариулсан байна. 3, 4-р ангид англи хэл үзэх шаардлагатай гэж үзэж байна уу гэсэн асуултанд хариулсан Pre-Intermediate түвшний 158 оюутны 86,7% нь тийм, 13,3% нь үгүй гэж хариулсан бол Intermediate болон Upper-Intermediate түвшний нийт 193 оюутны 92,2% нь тийм, 7,8% нь үгүй гэж хариулжээ. Хэрэв шаардлагатай гэж үзэж байгаа бол ямар хэлбэрээр үзэх шаардлагатай гэж үзэж байна гэсэн асуултанд хариулсан Pre-Intermediate түвшний 137 оюутны 51,8% нь заавал үзэх хэлбэрээр, 45,2% нь сонгон, 3% нь төлбөртэй сургалт хэлбэрээр үзэх нь зөв гэж хариулсан бол Intermediate болон Upper-Intermediate түвшний нийт 178 оюутны 53,4% нь заавал үзэх хэлбэрээр, 46,6% сонгон суралцах хэлбэрээр судлах нь зөв гэсэн бол, энэ түвшний нэг ч оюутан төлбөртэй судлах хэлбэрээр гэсэн хариултыг сонгоогүй байна.

Үүнээс үзэхэд их дээд сургуулиудад зөвхөн 1,2-р ангиудад ерөнхий болон мэргэжлийн англи хэлний хичээл зааж 3,4-р ангиудад англи хэлний хичээл ордоггүй нь төгсөгчдийн англи хэлний мэдлэг гологдох гол шалтгаан болж байна гэж нэг талаас үзэж болохоор байна. Оюутнуудын 74% нь тэдний мэргэжлийн хувьд англи хэл маш их шаардлагатай гэж үзсэн, мөн бүх түвшний оюутнууд 3,4-р курсуудад англи хэл үзэх сонирхолтой байгаагаас харвал ажил олгогчдын эрэлт хэрэгцээг хангахын тулд дээд сургуульд үзэж байгаа хэлний мэргэжлийн бус англи хэлний хичээлийн цагийг нэмэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

4. Сургалтанд ашиглаж байгаа сурах бичгийн ашиглалтыг дээшлүүлэх

ЭЗС-ийн англи хэлний сургалтанд хэрэглэж байгаа дээр дурьдсан ерөнхий болон бизнесийн англи хэлний хоёр сурах бичгийг судалгаанд хамрагдсан оюутнуудын 69,9% нь тэдний хэрэгцээнд сайн тохирч байна, 19,9% нь дунд зэрэг, 9,09% нь маш сайн, 1,1%-нь нийцэхгүй байна гэж хариулжээ.

Сурах бичгүүд тэдний хэрэгцээнд “дунд зэрэг” нийцэж байна гэсэн хариулт өгсөн Upper-Intermediate, Intermediate түвшний оюутнууд маш бага хувь эзэлж байгаа ч гэсэн шалтгааныг тайлбарлахдаа Face2Face хэт энгийн, уйтгартай, байнга дасгал ажилладаг, гэсэн бол уг хоёр номын хувьд дан нэг номоор дагнаж явдаг, өөр олон хэрэгтэй материал нэмж оруулах хэрэгтэй, сонсох, бичих, ярих чадварыг илүү хөгжүүлэх чиглэлээр нэмэлт ажлуудыг түлхүү хийлгэмээр байна, гэсэн бол Pre-Intermediate түвшний “дунд зэрэг” хариулт сонгосон оюутнууд уг сурах бичгүүдийг хэт нуршуу, суурь муу болохоор ойлгодоггүй гэсэн шалтгаануудыг тоочсон байна. Харин “нийцэхгүй” гэсэн хариулт өгсөн 4 оюутнууд Upper-Intermediate, Intermediate түвшний оюутнууд байсан бөгөөд тэд 4 чадварыг зэрэг хөгжүүлсэн илүү академик ном хэрэгтэй, Face2Face хэтэрхий хялбар, дууриаж хийлгэх дасгал их байдаг тул үр өгөөжгүй, бүтээлчээр сэтгэх шаардлагыг үгүй болгодог, аль аль сурах бичгийн хувьд бичих чадварыг хөгжүүлэх дасгалуудыг нь хийлгэдэггүй, бичих чадварыг хөгжүүлэх ном хэрэгтэй гэсэн шалтгаанууд бичжээ. Ерөнхийдөө оюутнууд ганц сурах бичгээр дагнаж явах нь өгөөжгүй байна, 4 чадварыг зэрэг хөгжүүлэх, үгийн баялгыг нэмэгдүүлэх эрчимтэй сургалт явуулах шаардлагатай байгааг нийтлэг дурьдсан байна. Мөн Upper-Intermediate түвшний оюутнууд 2 жил нэг түвшиндээ сурдаг гэсэн гомдолтой байна.

5. Англи хэлний багш нарыг мэргэжил дээшлүүлэх, орчин үеийн заах арга зүйн сургалт семинарт тогтмол хамруулж байх

Судалгаанд оролцсон оюутнуудын 286 оюутан буюу 81,3% нь англи хэлний хичээл сонирхолтой байдаг гэж хариулсан нь ЭЗС-ийн англи хэлний багш нарын ажлын үзүүлэлт сайн байгааг харуулж байна. ЭЗС-д элссэнээс хойш англи хэлний мэдлэг дээшилсэн эсэх асуултанд түвшингээр нь ялгаж авч үзвэл Pre-Intermediate түвшний 16 оюутан маш их дээшилсэн, 100 оюутан тодорхой хэмжээгээр, 36 оюутан бага зэрэг, 4 оюутан огт дээшлээгүй гэж хариулсан байна. Харин Intermediate болон Upper-Intermediate түвшний оюутнуудын 6 нь маш их дээшилсэн, 118-тодорхой хэмжээгээр дээшилсэн, 61-бага зэрэг дээшилсэн, ба 11-огт дээшлээгүй гэсэн хариулт өгсөн байна. Үндсэндээ англи хэлний хичээлийн мэдлэг нь дээшилсэнд сэтгэл ханамжтай байгаа оюутны хувь 68,3% байгаа нь мөн өндөр үзүүлэлт боловч сургалтыг эрчимтэй явуулах шаардлага байгаа нь үлдсэн 31,7% нь бага зэрэг дээшилсэн гэсэн хариулт өгснөөс харагдаж байна. Мөн судалгаанд хамрагдсан оюутнуудын тэн хагасаас дээш хувь нь ярианы

болон бичгийн ур чадвар, уншиж ойлгох чадваруудаа дээшлүүлэх шаардлагатай байгааг дурьдсан байна. Энэ нь мөн бакалаврын албанаас явуулсан судалгаанд тодорхойлогдсон ажил олгогчдын эрэлт хэрэгцээтэй дүйцэж байна.

Дээд сургуулийн сургалтын байгууллагын хувьд багш нар бодлого хэрэгжүүлэгч хамгийн гол хүмүүс байдаг. Багш нарын мэдлэг чадвар, заах арга зүй сайн байж аливаа сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт сайн явагдах нь дамжиггүй. Орчин үед англи хэлний хөтөлбөрүүд, сурах бичгүүдэд харилцааны англи хэлийг онцгойлж үзэх болсон тул энэ нь багш нарыг байнга мэргэжил дээшлүүлэх, англи хэл заах сүүлийн үеийн дэвшилтэт арга зүйн сургалтуудад хамруулж байх эрэлт хэрэгцээг үүсгэж байна. Хамгийн наад зах нь МУИС-ийн хэмжээнд англи хэлний гадаад мэргэжилтэн багш байхгүй байгаа нь англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлэх талаар анхаарал бага тавигдаж байгааг харуулж байна.

**Хятад улсын их дээд сургуулиудад мөрдөгддөг хэлний
мэргэжлийн бус англи хэлний сургалтын үндэсний
хөтөлбөрийн тухай**

Энэ хөтөлбөрийн дагуу мэргэжлийн багш нараас бүрдсэн баг түвшин бүрт тохирсон үндэсний сурах бичгүүдийг боловсруулсан бөгөөд оюутнуудын мэдлэгийг дүгнэх нэгдсэн тестүүдийг боловсролын яамны холбогдох мэргэжилтнүүд тухай бүр боловсруулж сургалтын үр дүнг тооцдог байна. Анхны хөтөлбөрийг 1977 онд баталснаас хойш 4 удаа шинэчлэн сайжруулсан бөгөөд одоо мөрдөж байгаа дорх хөтөлбөр нь 2004 онд батлагдаж англи хэлний сургалтанд асар их ахиц дэвшил авчирсан гэж олон судлаачид үзсэн хэдий ч хэрэгжүүлэх түвшинд зарим хүндрэлүүд гарч байгаа талаар ч зарим судлаачид дүгнэсэн байна.

Энэ сургалтын хөтөлбөр нь их дээд сургуулийн хүмүүнлэгийн ухаан болон шинжлэх ухааны салбарт суралцагсдад зориулсан англи хэлний хөтөлбөр байна.

I. Хөтөлбөрт хамрагдах оюутнуудад тавигдах хэлний шаардлага

Энэ хөтөлбөрөөр хичээллэж эхлэгсэд англи хэлний дуудлага, хэлзүйн суурь мэдлэгийг эзэмшсэн байх бөгөөд 1600 үг мэддэг байх шаардлагатай. Энэ үгнүүдээс оюутан 1200 үгийг зөв бичиж, үндсэн утга болон хэрэглээг мэддэг байх ёстой. Мөн унших, сонсох, бичих болон ярианы анхан шатны мэдлэгийг эзэмшсэн байх шаардлага тавигдана.

II. Хөтөлбөрийн Зорилго

Уг хөтөлбөр нь оюутанд харьцангуй өндөр түвшний уншиж ойлгох чадвар, дунд түвшинд сонсож ойлгох чадвар, суурь түвшинд бичиж, ярих чадварыг эзэмшүүлэхийг зорино. Хөтөлбөрийг дүүргэсний дараа оюутнууд өөрсдийн мэргэжлийн хүрээнд шаардлагатай байгаа ямар ч мэдээллийг англи хэл дээр ашиглах, цаашид англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх баттай суурь тавигдсан байна.

III. Сургалтын хөтөлбөрийн үр дүнд тавигдах шаардлага

Уг хөтөлбөр нь хоёр үе шаттай: суурь үе шат ба мэргэжлийн үе шат. Энэ хоёр үе шатуудад тавигдах шаардлага нь:

А. Суурь үе шат

Энэ үе шат нь түвшин ахисан зургаан түвшний сургалтаас бүрдэнэ. (College English Bands 1-6, товчилсон CEBs1-6). Элсэгчдийн англи хэлний мэдлэгийн түвшин өөр өөр байх нь ойлгомжтой учир суурь үе шатны сургалтыг 2 зэрэглэлээр төгсгөдөг. Эхний 4 түвшний сургалтыг амжилттай дүүргэсэн оюутнуудыг суурь түвшний шаардлагыг хангасан гэж үзэх ба 6-р түвшний сургалтыг амжилттай дүүргэсэн оюутныг дээд түвшний шаардлагыг хангасан гэж үзнэ.

1. Суурь түвшний шаардлагууд (эхний 4 түвшний сургалтын дараа)

1) *Дуудлага*: Оюутнууд англи үг болон бичвэрийг чангаар уншихдаа дуудлага болон өргөлтийг ойлгогдох хэмжээнд зөв дуудна.

2) *Үгсийн сан*: Оюутнууд 4000 үг болон хамгийн их давтамжтай хэрэглэгддэг тодорхой тооны хэллэгүүдийг таних ёстой. Мэдэхгүй үгний утгыг үг бүтээх үндсэн дүрмийн тусламжтай тааж олох чадвар суусан байна. Дээрх 4000 үгнээс 2300 үгийг зөв бичиж, үндсэн утга болон хэрэглээг мэдэж байх ёстой.

3) *Хэлзүй*: Оюутнууд дүрмийн талаарх суурь мэдлэгээ дээшлүүлэхдээ тэднийг харилцан ярианд хэрэглэх чадвараа хамт хөгжүүлсэн байвал зохино.

4) *Унших*: Оюутнууд ерөнхий сэдвүүдийн хүрээнд дунд түвшинд (Intermediate) текстүүдийг түвэггүй уншиж сурсан байна. Унших хурд минутанд 50 үгнээс багагүй байна. Текстийн нийт үгний 2% -иас илүүгүй шинэ үг орсон арай хялбар текстүүдийн хувьд унших хурд нь минутанд 90 үг байх ба наад зах нь утгын 70% -ыг ойлгосон байх ёстой.

5) *Сонсох*: Оюутнууд англи хэлээр хэлж байгаа заавруудыг ойлгох чадвар суусан байна. Мөн танил сэдвүүдээр минутанд 120 үг хэлэх хурдтайгаар ярьж байгаа яриаг зөвхөн нэг удаа сонсоод ойлгох чадвар суусан байна. Эдгээр сонсох яриануудад маш цөөхөн шинэ үг байх ёстой ба унших текстүүдийг бодвол харьцангуй хялбар энгийн материалууд байх ёстой. Оюутнууд уг сонсох материалын 70%-иас доошгүйг ойлгосон байх чадвар сууна.

6) *Бичих*: Өгсөн зааварчилгааны дагуу тухайн өгөгдсөн сэдвээр оюутнууд 30 минутын дотор 100-120 үгтэй зохион бичлэг бичих чадвар суусан байна. Зохион бичлэгийг логик уялдаа холбоо сайтай, дүрмийн ноцтой алдаа гаргалгүй бичсэн байх ёстой.

7) *Яриа*: Өдөр тутмын яриаг оюутнууд энгийн англи хэлээр үргэлжлүүлэх чадвар суусан байх ба өгөгдсөн текстэн дээр асуулт хариулт өгч сурсан байна.

2. 6-р түвшний сургалтын дараа тавигдах дээд түвшний шаардлага

1) *Үгсийн сан*: Оюутнууд 5,300 үг, байнга хэрэглэгддэг тодорхой тооны үг хэллэгүүдийг танидаг болсон байна. Эдгээрээс ойролцоогоор 2,800 үгийг зөв бичиж, үндсэн утга болон хэрэглээг мэддэг болсон байна.

2) *Унших*: Оюутнууд харьцангуй ахисан түвшинд ерөнхий сэдвүүдийн хүрээнд бичсэн ахисан түвшний текстүүдийг түвэггүй уншиж ойлгох чадвар суусан байна. Унших хурд минутанд 70 үгнээс багагүй байх ёстой. Текстэнд байгаа нийт үгнээс шинэ үг 3%-иас хэтрэхгүй байх арай хялбар текстүүдийн хувьд унших

хурд минутанд 120 үгнээс доошгүй байх ба доод тал нь 70%-ийг нь ойлгосон байх чадвар суусан байна.

3) *Сонсох:* Танил сэдвүүдийн хүрээнд сонсох материалуудын доод тал нь 70%-ийг сонсож ойлгох чадвар суусан байна. Эдгээр материалуудад шинэ үг маш бага байх ба минутанд 140 үг хэлэх хурдтайгаар зөвхөн нэг удаа сонсоно.

4) *Бичих:* Оюутнууд 30 минутанд 120-150 үгтэй логик дэс дараалалтай богино зохион бичлэг (абстракт гэх мэт) бичих чадвар суусан байна.

5) *Яриа:* Урьдчилсан бэлтгэлтэйгээр ямар нэг текстийн утгыг товч ярих юм уу тодорхой нэг хэлэлцүүлгийн асуудлаар товч ярих чадвар суусан байна. Оюутнууд санаагаа сонсож байгаа хүмүүсээс авах чадвартай байх ёстой.

В. Мэргэжлийн үе шат

Сургалтын энэ үе шатны төгсгөлд оюутнууд дараах шаардлагуудыг хангасан байвал зохино:

1) Өөрсдийн мэргэжилтэй холбогдолтой өгүүллэг, номыг түвэггүй уншиж ойлгох чадвар суусан байна.

2) Эдгээр материалуудыг минутанд 70-аас доошгүй үг унших хурдтайгаар уншиж доод тал нь 70%-ыг нь ойлгох чадвар суусан байна.

3) Тэдний англиар унших материалын хэмжээ 250,000 үгнээс доошгүй үгтэй байна.

IV. Сургалтын Бүтэц

А.Сургалтын суурь үе шат

Энэ үе шатанд ангид үзэх нийт цаг нь дээд сургуулийн эхний 4 улиралд 280 цагаас багагүй байна. Нэг түвшний (band) сургалт хичээлийн нэг семестерт багтана. 7 хоногт 4 цагийн хичээл орох ба нэг цаг ангид хичээл орсны дараа гэрийн даалгавар шалгахад доод тал нь 2 цагийг зориулна.

Хичээл эхлэхээс өмнө оюутнуудыг түвшингээр нь ялгахын тулд C тест авч 6 түвшиндээ (band) хуваана. Ихэнх тохиолдолд оюутнууд 1-р түвшингээс эхэлж 4-р түвшинг дуустал хичээллэдэг. 2 болон 3-р түвшингээс эхэлсэн оюутнууд 5 болон 6-р түвшинд шилжин суралцана. Улирал бүрийн эцэст юмуу хичээлийн жилийн эцэст оюутнуудыг гүйцэтгэлийн үр дүнгээр нь тохирох түвшний ангиудад дахин хуваарилна. Түвшин дээшилж сурах сонирхолтой оюутнаас шалгалт авч шаардлага хангасан тохиолдолд дээд түвшний анги руу дэвшүүлэн сургаж болно.

В. Мэргэжлийн үе шат

Англи хэлийг үргэлжлүүлэн сурах, мэргэжлийн холбогдох мэдээллийг олж авахын тулд англи хэл дээр мэргэжлийн ном хэвлэл уншиж сурах хэрэгцээг дэмжихийн тулд их сургуулийн 5 дахь семестрээс 7-р семестер дуустал мэргэжлийн текст унших чадвар олгох англи хэлний хөтөлбөрүүдийг холбогдох мэргэжлийн багш нараар заалгана. Энэ нь 7 хоногт 2 цаг орох заавал үзэх хичээл байна.

Мэргэжлийн англи текст унших чадвар олгох хичээл нь дараах хоёр байдлаар явагдаж болно:

- 1) Тухайн мэргэжлийн холбогдолтой англи сурах бичгийг ашиглах.
- 2) Хичээлээс гадуур унших англи хэл дээр бичигдсэн гарын авлагуудыг оноож өгөх

С. Сонгон суралцах хичээл

Хэрэв сургуулийн сургалтын хөтөлбөрт харшлахгүй бол 3-р курсээс эхлэн илүү ахисан түвшний англи хэлний хичээлүүдийг сонгон суралцах маягаар үзэж болно. Гэхдээ эдгээр сонгон суралцах хичээлүүд нь мэргэжлийн текст англиар унших чадвар олгох хичээлүүдийг ямар ч байдлаар орлохгүй.

Сургалтын хөтөлбөрт багтааж болох зарим сонгон суралцах хичээлүүд

5-р түвшний сургалт: 4-р түвшний сургалтыг амжилттай төгсөгчид

6-р түвшний сургалт: 5-р түвшинг амжилттай дүүргэсэн оюутнууд

Уран зохиолын төрөл бүрийн түүвэр зохиолууд

Доод тал нь 4-р түвшний сургалтыг амжилттай дүүргэсэн оюутнууд дараах хичээлээс сонгон суралцаж болно:

Орчуулга

Ахисан түвшний (advanced) сонсох

Ахиса түвшний (advanced) яриа

Бичих чадвар

Д. Бэлтгэл сургалт

1-р түвшний (CEB 1) шаардлагад тохирохгүй англи хэлний мэдлэгтэй оюутнуудын хувьд хоёр түвшний бэлтгэл сургалтыг явуулна. Эдгээр нь бэлтгэл-1, бэлтгэл-2 курсууд байна. Бэлтгэл-1 курсийн хувьд оюутнууд дуудлагын болон дүрмийн урьдчилсан сургалтанд хамрагдсан байх ёстой ба 700 үг таньж байх ёстойгоос 500 үгийг зөв бичиж, үндсэн утга, хэрэглээг нь мэдэж байх ёстой. Бэлтгэл-2 курсийн хувьд дуудлага болон дүрмийн урьдчилсан сургалтанд хамрагдсан байх ба 1100 үг таньж байх ёстойгоос 850 үгийг нь зөв бичиж, үндсэн утга, хэрэглээг нь мэдэж байх шаардлага тавигдана.

Гол их дээд сургуулиудын хувьд 1-р болон 2-р түвшингээс эхэлсэн оюутан 4-р түвшинг дуустал заавал суралцсан байх ёстой. Бусад их дээд сургуулиудын хувьд төгсөгчдийн англи хэлний минимум шаардлагыг өөрсдөө тогтооно.

Энэ хөтөлбөрийн дагуу мэргэжлийн багш нараас бүрдсэн баг түвшин бүрт тохирсон үндэсний сурах бичгүүдийг боловсруулсан бөгөөд оюутнуудын мэдлэгийг дүгнэх нэгдсэн тестүүдийг боловсролын яамны холбогдох мэргэжилтнүүд тухай бүр боловсруулж сургалтын үр дүнг тооцдог байна. Анхны хөтөлбөрийг 1977 онд баталснаас хойш 4 удаа шинэчлэн сайжруулсан бөгөөд одоо мөрдөж байгаа дорх хөтөлбөр нь 2004 онд батлагдаж англи хэлний сургалтанд асар их ахиц дэвшил авчирсан гэж олон судлаачид үзсэн хэдий ч хэрэгжүүлэх түвшинд зарим хүндрэлүүд гарч байгаа талаар ч зарим судлаачид дүгнэсэн байна.

Дүгнэлт

Англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлэхэд сайн боловсруулсан хөтөлбөр онцгой ач холбогдолтой байх нь тодорхой юм. Ер нь аливаа хэлийг эрчимтэй шахуу хөтөлбөрөөр үзэж сургалтын үр дүнг системтэй дүгнэн нэг түвшингээс нөгөө түвшин рүү шилжүүлэх байдлаар явуулахад үр дүн сайтай байдаг нь харагддаг. Ингээд англи хэлний хөтөлбөрийг сайжруулах хэрэгцээ байгааг тодруулах зорилгоор хийсэн судалгааны үр дүнд дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Их дээд сургуулийн хэлний мэргэжлийн бус ангиудын англи хэлний сургалтын чанарыг сайжруулахын тулд ерөнхий боловсролын сургуулиудын англи хэлний сургалтыг сайжруулах, сургалтын хөтөлбөрийг нь их дээд сургуулиудын хөтөлбөртэй уялдуулах шаардлагатай байна.
2. МУИС-ийн хэмжээнд англи хэлний хичээлийг заахдаа оюутнуудыг хэлний мэдлэгийн түвшингээр нь хувааж бүлэг болгон хичээллүүлэх боломжоор жигд хангах шаардлагатай байна.
3. Англи хэлний хичээл 7 хоногт 4 цагаар орж байгааг хангалттай гэж үзэж байна уу гэсэн асуултанд хариулсан Pre-Intermediate түвшний 159 оюутны 71,6% нь хангалттай, 28,4% нь хангалтгүй, Intermediate болон Upper-Intermediate түвшний нийт 193 оюутны 64,2% нь хангалттай, 35,8% нь хангалтгүй гэж хариулсан байна. 3, 4-р ангид англи хэл үзэх шаардлагатай гэж үзэж байна уу гэсэн асуултанд хариулсан Pre-Intermediate түвшний 158 оюутны 86,7% нь тийм, 13,3% нь үгүй гэж хариулсан бол Intermediate болон Upper-Intermediate түвшний нийт 193 оюутны 92,2% нь тийм, 7,8.% нь үгүй гэж хариулжээ. Үүнээс үзэхэд их дээд сургуулиудад зөвхөн 1,2-р ангиудад ерөнхий болон мэргэжлийн англи хэлний хичээл зааж 3,4-р ангиудад англи хэлний хичээл ордоггүй нь төгсөгчдийн англи хэлний мэдлэг гологдох гол шалтгаан болж байна гэж нэг талаас үзэж болохоор байна. Оюутнуудын 74% нь тэдний мэргэжлийн хувьд англи хэл маш их шаардлагатай гэж үзсэн, мөн бүх түвшний оюутнууд 3,4-р курсуудад англи хэл үзэх сонирхолтой байгаагаас харвал ажил олгогчдын эрэлт хэрэгцээг хангахын тулд дээд сургуульд үзэж байгаа хэлний мэргэжлийн бус англи хэлний хичээлийн цагийг нэмэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.
4. Дээд сургуулийн сургалтын байгууллагын хувьд багш нар бодлого хэрэгжүүлэгч хамгийн гол хүмүүс байдаг. Багш нарын мэдлэг чадвар, заах арга зүй сайн байж аливаа сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт сайн явагдах нь дамжиггүй. Орчин үед англи хэлний хөтөлбөрүүд, сурах бичгүүдэд харилцааны англи хэлийг онцгойлж үзэх болсон тул энэ нь багш нарыг байнга мэргэжил дээшлүүлэх, англи хэл заах сүүлийн үеийн дэвшилтэт арга зүйн сургалтуудад хамруулж байх эрэлт хэрэгцээг үүсгэж

байна. Хамгийн наад зах нь МУИС-ийн хэмжээнд англи хэлний гадаад мэргэжилтэн багш байхгүй байгаа нь англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлэх багш нарт зааж байгаа хэлээрээ өдөр тутам харилцаанд орж ярианы хэлээ дадлагажуулах, ингэснээр хичээлийн чанарыг дээшлүүлэх талаар удирдлагаас анхаарал бага хандуулж байгааг харуулж байна.

5. Одоо боловсруулж байгаа МУИС-ийн Англи хэлний сургалтын стандартад хятадын дээд сургуулиудад мөрдөж байгаа хөтөлбөрөөс санаа авч тусгах, уг стандартыг англи хэлний сургалтын өнөөгийн байдал, суралцагчид болон бусад оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд тулгуурлан тэдний дунд өргөн цар хүрээтэй судалгаа явуулсны үндсэн дээр шинжлэх ухааны үндэслэлтэй, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулах шаардлагатай байна. Стандартыг боловсруулахад гадны хөгжилтэй орнуудын сургалтын хөтөлбөрийг шууд хуулбарлах биш өөрсдийн нөхцөлд таарах, оролцогч талуудын эрэлт хэрэгцээг илүү анхаарсан шийдэл гаргах хэрэгтэй болов уу.

Ном зүй.

1. Harmer, J. (1991). *The Practice of English Language Teaching*: London. Longman.
2. Richards, J.C., & Rogers, T. (1986). *Approaches and Methods in Language Teaching*. New York. Cambridge University Press.
3. Cunningsworth, A 1995. 'Choosing Your Coursebook'; Heinemann
4. Jim Scrivener, 2007, 'Learning Teaching': Macmillan, Oxford
5. Christopher Reznich, 1985, 'Teaching Teachers': The Consortium, USA
6. МУИС-ийн ЭЗС-ийн оюутнуудын дунд явуулсан судалгаа, 2011, Улаанбаатар
7. Ineta Luka, 2005, 'Development of students' English for special Purposes competence in tourism studies at Tertiary level', Latvia
8. John Gunning, 2009, 'An immodest proposal for tertiary level EFL: An interview with Mike Guest', Japan
9. МУИС-ийн БСА-ны тайлан, 2009
10. Hong Wang, 2006 'An implementation study of the English as a foreign language curriculum policies in the chinese tertiary context' Ontario, Canada
11. БСШУЯ-ны сайт: www.mecs.gov.mn